

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОБЪЕКТ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ"-ЫН ШИНЭЧЛЭН
БОЛОВСРУУЛСАН ТӨСӨЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох (цаашид “гэрчилгээжүүлэх” гэх) үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангаж, осол, зөрчил гарахгүй байх урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.
- 1.4. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагаанд нээлттэй, ил тод, ёс зүйтэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.
- 1.5. Гэрчилгээ нь норм нормативын баримт бичиг, стандартад заасан шаардлагыг хангасан эсэхийг нотолж, тухайн объектыг ашиглах, үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн баримт бичиг бөгөөд эд хөрөнгө өмчлөх, газар эзэмших, ашиглах харилцаанд хамааралгүй болно.
- 1.6. Энэхүү журамд хэрэглэх нэр томъёо, тодорхойлолтыг Төмөр замын тээврийн тухай хууль, үндэсний стандартад заасан утгаар ойлгоно.
- 1.7. Төмөр замын үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь объект, үйл ажиллагааны гэрчилгээ авсан тээвэрлэлтэд оролцогч этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулна.
- 1.8. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны зардлыг гэрчилгээ олгох байгууллага хариуцна. Гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн гишүүн, шинжээч, улсын байцаагч, эрдэм шинжилгээний ажилтны очиж ажиллах томилолтын зардлыг хүсэлт гаргагч хариуцна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ОБЪЕКТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУГАЦАА

2.1. Гэрчилгээжүүлэх объект

- 2.1.1. салбар зам /гарам, пүү/;
- 2.1.2. өртөө, зөрлөг;
- 2.1.3. гарам /суурь бүтэц дэх/;
- 2.1.4. шилжүүлэн ачих терминал;
- 2.1.5. ачиж буулгах талбай;
- 2.1.6. хөдлөх бүрэлдэхүүн;
- 2.1.7. зам угсрах, засварлах, сэргээн босгох машин механизм.

2.2. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа

- 2.2.1. салбар зам, талбай барих;
- 2.2.2. салбар замын засвар, арчлалт;
- 2.2.3. салбар замд сэлгээний ажил гүйцэтгэх;
- 2.2.4. хөдлөх бүрэлдэхүүний операторын үйл ажиллагаа эрхлэх;
- 2.2.5. дохиолол, холбооны байгууламжийн техникийн үйлчилгээ;
- 2.2.6. зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ

- 2.2.7. вагоны техникийн үзлэг, үйлчилгээ;
 - 2.2.8. аюултай ачаа тээвэрлэх;
 - 2.2.9. тусгай зориулалтын багаж, хэрэгсэл үйлдвэрлэх, хилээр оруулж ирэх;
 - 2.2.10. төмөр замын тээвэр зуучлал;
- 2.3. Гэрчилгээжүүлэх эд анги /Монгол Улсад үйлдвэрлэсэн/
 - 2.3.1. суурь бүтцийн эд анги;
 - 2.3.2. хөдлөх бүрэлдэхүүний эд анги.
- 2.4. Гэрчилгээний хүчинтэй хугацаа
 - 2.4.1. объектын гэрчилгээг 3-5 жил хугацаагаар олгоно. Салбар замын гэрчилгээг зураг төслийг үндэслэн 10 жил хүртэлх хугацаагаар олгож болно. Хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээг холбогдох стандартын дагуу ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаагаар олгож болно.
 - 2.4.2. үйл ажиллагааны гэрчилгээг 3 жил хугацаагаар олгоно.
 - 2.4.3. гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж хугацаа нь дууссанаар хүчингүйд тооцно.

ГУРАВ. ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

- 3.1. Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
 - 3.1.1. энэхүү журам, гэрчилгээжүүлэх нөхцөл, шаардлагыг батлах;
 - 3.1.2. гэрчилгээ олгох шийдвэр гаргах;
 - 3.1.3. гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг хянах, зөрчлийг арилгуулах.
 - 3.1.4. гэрчилгээжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гомдол хянаж шийдвэрлэх;
 - 3.1.5. гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн тушаал, эд анги, баримт бичгийн жагсаалтыг хянаж, зөвшөөрөх.
- 3.2. Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
 - 3.2.1. гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, гэрчилгээжүүлэх объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох,
 - 3.2.2. Монгол Улсад хилээр орж ирсэн хөдлөх бүрэлдэхүүнд гэрчилгээ олгох. Хөдлөх бүрэлдэхүүнийг ашиглах талаар дүгнэлт гаргах, бүртгэх, дугаар олгох асуудлыг энэхүү журмаар зохицуулахгүй;
 - 3.2.3. гэрчилгээжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай мөрдөх норм, стандарт боловсруулах, батлуулах
 - 3.2.4. гадаад улсад үйлдвэрлэсэн төмөр замын тээврийн объектын гэрчилгээг хүлээн зөвшөөрөх, татгалзах мөн норм, стандарт судлах, гэрчилгээжүүлэх асуудлаар гадаад улсын ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;
 - 3.2.5. гадаадын хөрөнгө оруулалтай хуулийн этгээд үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгох зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах. Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газарт үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгохгүй;

- 3.2.6. гэрчилгээжүүлэх объект, үйл ажиллагаа, нөхцөл, шаардлага, үйл ажиллагааг цаг үетэй нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт хийх санал боловсруулах;
- 3.2.7. гэрчилгээний загвар, код, үндэслэл /норм, стандарт/, техникийн үзүүлэлт, бусад мэдээллийн агуулгыг батлах;
- 3.2.8. гэрчилгээний мэдээллийн сан, бүртгэл хөтлөх;
- 3.2.9. гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу явуулж байгаа эсэхийг хянаж, зөрчлийг арилгах;
- 3.2.10. төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах;
- 3.2.11. гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх байнгын, орон тооны бус ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсэг ажиллах журам батлах. Ажлын хэсэгт техникийн шинжээч, улсын байцаагчийг татан оролцуулах, эрдэм шинжилгээний байгууллага, бусад ижил төстэй байгууллагын дүгнэлт ашиглах;
- 3.2.12. гэрчилгээжүүлэх суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний эд ангийн жагсаалт батлах.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ,
СУНГАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, НӨХӨН ОЛГОХ**

- 4.1. Объектын гэрчилгээ олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ.
 - 4.1.1. гэрчилгээ хүссэн өргөдөл;
 - 4.1.2. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;
 - 4.1.3. объектод газар эзэмших асуудал хамаарах бол түүний гэрчилгээ, гэрээ /кадастрын зураг/
 - 4.1.4. техникийн паспорт, тухайн орны гэрчилгээ эсвэл тохирлын гэрчилгээ, оношилгоо хийсэн тухай баримт бичиг;
 - 4.1.5. ашиглалт болон аюулгүй ажиллагааны заавар;
 - 4.1.6. гүйцэтгэлийн зураг, ашиглалтад оруулсан дүгнэлт, засвар арчлалтын гэрээний хуулбар, техникийн иж бүрэн үзлэгийн акт /салбар замд хамаарна/;
 - 4.1.7. өөрийн өмчийг нотолсон баримт бичиг.
- 4.2. Үйл ажиллагааны гэрчилгээ олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ.
 - 4.2.1. гэрчилгээ хүссэн өргөдөл;
 - 4.2.2. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - 4.2.3. технологийн горим, заавар;
 - 4.2.4. холбогдох нөхцөл шаардлагын дагуу хүний нөөцийн мэдээлэл /иргэний үнэмлэх, диплом, хөдөлмөрийн гэрээ, мөн түүний туршлагыг нотлох баримт бичиг/, байр, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж эзэмших гэрчилгээний хуулбар, фото зураг;
 - 4.2.5. мөрдөж байгаа хууль тогтоомж, стандартын жагсаалт, норм нормативын баримт бичгийн эх хувь.
- 4.3. Эд ангид гэрчилгээ олгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- 4.3.1. гэрчилгээ хүссэн өргөдөл;
- 4.3.2. улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;
- 4.3.4. техникийн даалгавар, зураг төсөл, үйлдвэрийн технологи, туршилтын дүн;
- 4.3.5. техникийн паспорт, тохирлын гэрчилгээ;
- 4.3.6. ашиглалт болон аюулгүй ажиллагааны заавар;
- 4.3.7. шаардлага хангаж байгаа гэх үндэсний норм, стандарт.

4.4. Гэрчилгээ сунгахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

- 4.4.1. Сунгуулах тухай өргөдөл /гэрчилгээний хугацаа дуусахаас өмнө/;
- 4.4.2. Өмнө олгосон объект, үйл ажиллагааны гэрчилгээ;
- 4.4.3. Хөдлөх бүрэлдэхүүний холбогдох засвар, үйлчилгээг хийсэн тухай нотлох баримт бичиг /гэрээ болон гүйцэтгэлийн мэдэгдэл, акт/, оношилгоо хийсэн тухай баримт бичиг;
- 4.4.4. Салбар замд засвар, үйлчилгээг хийсэн тухай нотлох баримт бичиг /гэрээ болон гүйцэтгэлийн мэдэгдэл, акт/, техникийн зургийн хуулбар /10 жил болсон бол шинэ гүйцэтгэлийн зураг/;
- 4.4.5. Үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа талаарх тайлан.

4.5. Гэрчилгээг түдгэлзүүлэх, сэргээх

- 4.5.1. Гэрчилгээ түдгэлзүүлэх, сэргээх үндэслэл
 - 4.5.1.1. гэрчилгээний нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон, зөрчсөн;
 - 4.5.1.2. гэрчилгээ эзэмшигчийн хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, байгууллага хохирсон, эрх ашиг зөрчигдсөн;
 - 4.5.1.4. төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагчийн түдгэлзүүлэх, сэргээх санал.

4.6. Гэрчилгээг хүчингүй болгох

- 4.6.1. гэрчилгээ эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан;
- 4.6.2. гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн;
- 4.6.3. гэрчилгээг түдгэлзүүлсэн хугацаанд шаардлага биелүүлээгүй;
- 4.6.4. гэрчилгээжүүлэлтийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 4.6.5. төмөр замын тээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, хүчингүй болгох санал гарсан;
- 4.6.6. гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан.

4.7. Гэрчилгээг нөхөн олгох

- 4.7.1. объектын гэрчилгээний хүчинтэй хугацаанд өмчлөгч буюу хууль ёсны эзэмшигч солигдсон;
- 4.7.2. гэрчилгээг үрэгдүүлсэн, бохирдуулсан.

4.8. Гэрчилгээжүүлэх ажлыг хэрэгжүүлэх байгууллага нь энэхүү 4 дүгээр бүлэгт заасан бүрдүүлэх баримтад нийцүүлэн илүү нарийвчилсан бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт гаргаж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ
АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

5.1. Гэрчилгээжүүлэх ажлын хэсэг /цаашид “ажлын хэсэг” гэх/ объект, үйл ажиллагаанд гэрчилгээг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай дүгнэлт гаргана.

5.2. Ажлын хэсэг нь ажлын хэсгийн дарга, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, гишүүд болох холбогдох чиглэлийн улсын байцаагч, мэргэжилтнүүдээс бүрдсэн орон тооны бус, тэгш тоотой байна. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь гэрчилгээжүүлэх ажлыг хариуцсан мэргэшсэн ажилтан байх ба саналын эрхгүй байна.

5.3. Ажлын хэсгийн үйл ажиллагааны хэлбэр нь өргөдөл, хавсралт баримт бичгийг хянаж, хурлаар хэлэлцэж, дүгнэлт үйлдэх байна. Хурлыг цахимаар хийж болно.

5.4. Хүсэлтийг гэрчилгээжүүлэх асуудал хариуцсан мэргэжилтэн хуулийн хугацаанд шалгаж, ажлын хэсгээр хэлэлцүүлнэ.

5.5. Ажлын хэсгээр хэлэлцэж шаардлагатай гэж үзвэл шинжээч, улсын байцаагч, мэргэжилтнээр гэрчилгээжүүлэх объект, үйл ажиллагааг газар дээр нь хянах шалгуулж, дүгнэлт гаргуулж болно.

5.6. Гэрчилгээ эзэмшигч нь зөвхөн гэрчилгээнд заасан үйл ажиллагааг эрхэлнэ;

5.7. Гэрчилгээний хүчинтэй хугацаанд объект, үйл ажиллагааны хэвийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж болох бүтэц, технологийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь 30 хоногийн дотор энэ тухай Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдсэн байна;

5.8. Энэхүү журмын 5.7 дахь хэсэгт заасан өөрчлөлтийг хийсэн бол гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг нэмж тусгах буюу шинээр гэрчилгээ олгоно. Шинээр гэрчилгээ олгох асуудлыг энэ журмын 4 дүгээр бүлэгт заасны дагуу хянан шийдвэрлэнэ;

5.9. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага нь төмөр замаар зуучилж тээвэрлүүлсэн ачааны төрөл, хэмжээний тайланг тээвэрлэгчээр баталгаажуулан, жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ;

5.10. Гэрчилгээг цэвэр үзэмжтэй хадгалах;

5.11. Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, нормыг дагаж мөрдөх;

5.12. Иргэн, хуулийн этгээд нь төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэлтэд хамруулах, тэдгээрт хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, нормативын баримт бичгээр тавигдах нөхцөл, шаардлагыг хангах үүрэгтэй;

5.13. Энэхүү журмын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН САН, БҮРТГЭЛ

6.1. Гэрчилгээжүүлэх мэдээллийн сан дараах мэдээллийг агуулна:

- гэрчилгээ хүссэн өргөдөл, бүрдүүлсэн баримт бичиг стандарт, норм, нормативын баримт бичиг;
- ажлын хэсгийн санал, дүгнэлт, олгох шийдвэр

- гэрчилгээжүүлсэн объект, үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, эд ангийн мэдээлэл;
- объектын дугаар, ангилал, төрөл;
- хүний нөөцийн мэдээлэл;
- Машин механизм, тээврийн хэрэгсэл, ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн мэдээлэл

6.2. Гэрчилгээ олгох шийдвэр гарсны дараа дээрх мэдээллийг цахимаар яаралтай мэдээллийн санд оруулна.

6.3. Нууцад хамаарахаас бусад мэдээллийг цахим хуудсанд байршуулна.

6.4. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, баримт бичгийг Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын архивт хадгална.

6.5. Мэдээллийн санд төвлөрсөн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглах үйл ажиллагааг “Архивын тухай” хуулиар зохицуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА

7.1. Энэхүү журмын заалтыг зөрчсөн буруутай этгээд Төмөр замын тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль эсвэл Эрүүгийн хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

8.1. Төмөр замын аюулгүй байдалтай холбоотой объектод тавих нөхцөл шаардлага

8.1.1. Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, норм, стандартын шаардлага хангасан;

8.1.2. Бүрдүүлэх баримт бичгийн шаардлага хангасан;

8.2. Төмөр замын аюулгүй байдалтай холбоотой зарим үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага

**ТӨМӨР ЗАМЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХОД ТАВИХ НӨХЦӨЛ
ШААРДЛАГА**

Үйл ажиллагааны төрөл	Байвал зохих инженер техникийн ажилтнууд	Инженер техникийн ажилтны ажлын туршлага	Бусад мэргэжлийн ажиллагсад	Бусад мэргэжлийн ажиллагсад тавигдах шалгуур	Үйл ажиллагааны суурь шаардлага	Үйл ажиллагаа эрхлэх ажлын байр, тоног төхөөрөмж
Салбар зам, талбай барих үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	Төмөр замын замын инженер-1, Геодези, хайгуул зураг төслийн инженер-1, Замын техникч-2,	Төмөр замын замын инженер нь мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.	Механикч-1, Төмөр замын замын мэргэжлийн ажилтан-5	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх	Салбар замын дээд, доод бүтцийн засвар, арчлалтын үйл ажиллагааг 3 жил зөрчил, дутагдалгүй гүйцэтгэсэн;	Багаж, тоног төхөөрөмж хадгалах талбай, агуулахтай байх, Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих багаж, хэрэгсэлтэй байх, Цахилгаан, хийн гагнуурын аппарат, Замын индүү, Усалгааны машин, Авто самосвал, Экскаватор, Грейдер, Замын домкрат, цахилгаан чигжүүр, цахилгаан үүсгүүр, замын чиг татагч
Салбар замын засвар арчлалт гүйцэтгэх үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага	Төмөр замын замын инженер-1	5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер	Замын техникч-2 Замын мэргэжлийн ажилтан-4	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх	-	Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: - Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих хэрэгсэл, - Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан багаж хэрэгсэлтэй байх,

<p>Салбар замд сэлгээний ажил гүйцэтгэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага</p>	<p>Тээвэр зохион байгуулалтын инженер-1,</p>	<p>Мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.</p>	<p>Найруулагч-2, Туслах найруулагч-2, Машинч-2, Туслах машинч-2.</p>	<p>Мэргэжлийн үнэмлэхтэй байх.</p>	<p>Сэлгээний зүтгүүрийн объектын гэрчилгээ Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх аюулгүй байдлын гэрчилгээ эсхүл зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ хийлгэх гэрээтэй байх, Сэлгээний ажлын заавар</p>	<p>Сэлгээний бригадын амрах байртай байх, Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: Радио станц, Албан яриа бичлэгийн төхөөрөмж, Тусгай зориулалтын багаж, хэрэгсэл.</p>
<p>Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний операторын үйл ажиллагааны нөхцөл шаардлага</p>	<p>Тухайн хөдлөх бүрэлдэхүүний мэргэжлийн инженер-1,</p>	<p>Мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.</p>	<p>Найруулагч-2, Туслах найруулагч-2, Машинч-2, Туслах машинч-2.</p>	<p>Мэргэжлийн үнэмлэхтэй байх.</p>	<p>Хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзлэг, үйлчилгээ хийх технологийн горим, Сэлгээний ажлын заавар</p>	<p>Зориулалттын ажил, амралтын байртай байх, Техник үзлэг, үйлчилгээ, засвар гүйцэтгэх зориулалтын засварын замтай байх, Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: Радио станц, Тусгай зориулалтын багаж, хэрэгсэл.</p>

<p>Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага</p>	<p>Зүтгүүрийн инженер-2</p>	<p>Төмөр замын их, дээд сургуулийг зүтгүүрийн инженер мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэг цолтой дүүргэсэн, мэргэжлээрээ 5 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.</p>	<p>Техникийн үйлчилгээний ажилтан-4, Гагнуурчин-1</p>	<p>1-ээс доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, мэргэжлийн диплом, үнэмлэхтэй эсхүл мэргэжлийн комисст шалгалт өгсөн байх.</p>	<p>Зүтгүүрийн техникийн үзлэг, үйлчилгээ хийх технологийн горим</p>	<p>Зориулалттын ажил, амралтын байртай байх, Техник үзлэг, үйлчилгээ, засвар гүйцэтгэх зориулалтын засварын замтай байх, Нөөц болон нэн шаардлагатай сэлбэг, материал, хатуу тооцоот багаж хэрэгслийг хадгалах байртай байх, Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага : Кран, Гагнуурын хэрэгсэл, Багаж хэрэгсэл, Нөөц сэлбэг, Зэхэлтийн тоног төхөөрөмж</p>
<p>Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага</p>	<p>Вагоны инженер-2</p>	<p>Төмөр замын их, дээд сургуулийг вагоны инженер мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэг цолтой дүүргэсэн, мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер байх.</p>	<p>Техник үйлчилгээний ажилтан-4, Гагнуурчин-1</p>	<p>1-ээс доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, мэргэжлийн диплом, үнэмлэхтэй эсхүл мэргэжлийн комисст шалгалт өгсөн байх.</p>	<p>Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ хийх технологийн горим</p>	<p>Зориулалттын ажил, амралтын байртай байх, Техник үзлэг, үйлчилгээ, засвар гүйцэтгэх зориулалтын засварын замтай байх, Нөөц болон нэн шаардлагатай сэлбэг, материал, хатуу тооцоот багаж хэрэгслийг хадгалах байртай байх, Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: Кран, Гагнуурын хэрэгсэл, Багаж хэрэгсэл, Нөөц сэлбэг, Зэхэлтийн тоног төхөөрөмж</p>

Аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага						
Төмөр замын дохиолол, холбооны байгууламжийн засвар, техникийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	Автомат, телемеханикийн инженер-2 /аль нэг нь мэргэшсэн инженер байх/ Холбооны инженер-1.	Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер	Механик-2 Холбооны техникч-1 Монтёр-3	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх.		Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай ажлын байртай байх; Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага : - Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан хэмжих хэрэгсэл - Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан багаж хэрэгсэл
Тусгай зориулалтын багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага	инженер-2 Чанар хэмжилтийн инженер-1	Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан эсхүл мэргэшсэн инженер	Токарьчин Халуун төмөрчин Мужаан Хэвлэгч Цутгуурчин Гагнуурчин	Мэргэжлийн диплом, үнэмлэхтэй байх.		Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын ажлын байртай байх: Үйлдвэрлэлийн байр, Хадгалах склад Суурь машины цех, Халуун төмрийн цех, Механик цех Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага: Токарийн суурь машин, Цахилгаан, Компютер Шалгах, турших багаж тоног төхөөрөмж /Эрх бүхий байгууллагаар баталгаажуулагдсан байх/ Гагнуурын аппарат /цахилгаан, хийн/

Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааны нөхцөл, шаардлага

Зайлшгүй байх мэргэжилтэн, тэдгээрийн тоо	Ажлын туршлага	Мэргэжилтэнд тавигдах шаардлага	Ажил үйлчилгээнд тавих суурь нөхцөл	Ажлын байранд тавигдах шаардлага	Тавигдах бусад шаардлага
Тээврийн мэргэжилтэн-2, санхүүгийн мэргэжилтэн-1,	Тээврийн мэргэжилтэн нь 3 мэргэжлээрээ болон түүнээс дээш жил ажилласан байх.	Тээврийн мэргэжилтэн нар нь тээврийн мэргэжлийн бакалавр ба түүнээс дээш зэргийн мэргэжлийн дипломтой байх, нэгээс доошгүй мэргэжилтэн нь тээвэр зуучлалын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх.	Үйл ажиллагааны гэрчилгээ олгосноос эсхүл сүүлийн жилийн тайлан ирүүлснээс хойш дараагийн тайлан ирүүлэх хугацаанд 10 вагон эсхүл 20 футийн чингэлэгт дүйцүүлсэн нэгж /TEU/-ээс доошгүй ачаа төмөр замаар зуучилсан байх	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай 25м@A2@B-аас доошгүй талбай бүхий ажлын байртай байх.	Төмөр замаар зуучилсан ачааны тайланг журмын хоёрдугаар хавсралтын дагуу тээвэрлэгчээр баталгаажуулан Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зам, тээврийн хяналтын нэгжид журамд заасан хугацаанд тайлагнах.

--- оОо---